

MICC ТЭМДЭГЛЭЛ

MICC.mn

2013 ОНЫ 10 ДУГААР САРЫН 16 (1)

14 хоног тутам гарна

MONGOLIA INTERNATIONAL CAPITAL CORPORATION — Монголын тэргүүлэх хөрөнгө оруулалтын корпораци

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ МЭДЭЭ

- Хятадын төмрийн хүдрийн импорт нэмэгдлээ. Тус улсын гангийн үйлдвэрлэл 9-р сард 100,000 тонн болсон байна. Өнгөрсөн онтой харьцуулахад даруй 8 хувиар нэмэгджээ.
- Монгол, Хятадын уул уурхайн хурал болж байна. Олон улсын гэсэн статустай уг хуралд хятадын талаас 150 компани, Монгол талаас Шивээ-Овоо, Эрдэнэт үйлдвэр, Монполимет, Тавантолгой ХК зэрэг 50 компанийн төлөөлөгч хүрэлцэн иржээ.
- Оросын En+group Азийн орнуудад нүүрс нийлүүлэх гэрээ байгуулав. Оросын уул уурхайн салбар дахь хувийн хэвшлийн томоохон компани болох En+group Өмнөд Солонгосын Поско, БНХАУ-ын төрийн өмчит China Coal компани болон Харбины төмөр замын товчоотой нүүрс нийлүүлэх урт хугацааны гэрээ байгуулжээ.
- Wolf Petroleum-ын хувьцаа 48 хувиар өслөө. Австралийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Монголын газрын тосны хайгуулын Wolf Petroleum компанийн хувьцааны ханш 48,89 хувиар өсч 0.045 австарли доллараас 0.067 болж хаагдсан бол дараа өдрийн өглөө 0.09 болж даруй нэг дахин өсчээ.
- Энэ оны 3-р улирлын байдлаар Монгол улсын нийт экспортын 25 хувийг нүүрс эзэлж байна. 11.3 сая тонн нүүрс экспортолж, 783.9 сая долларын орлого олсон нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад экспортын хэмжээ 20.4 %, үнийн дүн 45.3 %-р буурсан байна.
- БНХАУ-ын баруун хэсэгт орших Шиньжан-Уйгарын автономит районд нүүрс боловсруулан хий гаргах технологийн бүхий үйлдвэрийн томоохон цогцолбор байгуулахаар төлөвлөжээ. Төслийн хийт хөрөнгө оруулалт 30 тэрбум доллар.

Монголын хөрөнгийн зах зээл

Э. Оюу



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ зээлийн 90 орчим хувийг эзэлдэг, Монголын хамгийн өндөр үнэлгээтэй 20 хувьцаат компанийн хувьцааны үнийг нэгтгэж үзүүлдэг “ТОП 20 Индекс” өнөөдрийн байдлаар 13,989-д хүрч өчигдрийнхөөс 160 нэгжээр буюу 1.16 хувиар өссөн байна. Ер нь сүүлийн жил гаруй хугацаанд Топ 20 Индекс 13000–аас 14000–ын хооронд нилээд хэлбэлзлээ. Өөрөөр хэлбэл Монголын хөрөнгийн зах зээл дээрх компаниудын хувьцааны үнэ сүүлийн жил гаруй хугацаанд (дунджаар) өссөн ч үгүй, унасан ч үгүй. Үүнийг доорх зургаас тодорхой харж болно.

Топ 20 Индекс 2008 оноос хойш



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОДРУУЛГА

МИСС УУЛ УУРХАЙН ИНДЕКС



ӨНГӨРСӨН 1 САРД

Түүхий эдийн үнэ:

Алт ▲0.77% (\$1,282)

Зэс ▼% (\$7,407)

Коксжих нүүрс ▼0.9% (\$210.6)

Төмрийн хүдэр ▼7.0% (\$117.9)

Газрын тос (Сибир)▲0.21% (\$101.5)

Дэлхийн индексүүд:

S&P 500 ▼0.71% (1,698)

FTSE 100 ▼0.43% (6,520.6)

Nikkei 225 ▼0.2% (14,467)

MSCI EM ▼9.1% (902.6)

Твиттер ба түүнийг тойрсон асуудлууд

Твиттер компанийн хэрэглэгчдийн өсөлтийн тоо буурсан мөн шинжээчид ашиг олох боломжгүй гэж үзэж байна.

Өнгөрсөн долоо хоногт Твиттер компани нь анхдагч зах зээл дээр хувьцаагаа бүртгүүлж олон нийтэд зарласан. Сан-Франциско хотод байрлах энэхүү компанийн хувьцаа арилжаагдаж эхэлсэн даруйдаа компанийн нийт үнэлгээг 15-20 тэрбум доллар хүртэл өсгөх боломжтой хэмээн Ironfire Capital LLC болон Gamco Investors Inc (GBL) компаниуд мэдээлж байна.

Хүлээгдэж буй үнэ:

Sica-гаас мэдээлсэнээр Twitter-ын хувьцаа арилжаагдаж эхэлвэл компанийн нийт үнэлгээ 40 тэрбум ам долларт хүрнэ гэжээ. Хувьцаагаа гаргахаас өмнөх компанийн нийт үнэлгээ 12.8 тэрбум доллар байгаа юм. Одоогоор Твиттер гарах хувьцааныхаа үнийн хязгаарыг тогтоогоогүй байгаа эсвэл олон нийтэд ямар ханшаар хүрэх вэ гэдэгт хариу өгөхөөс татгалзсан тухай сурвалжлагч Jim Prosser мэдээлж байна.

Твиттер компани нь 8 сараас нийт 620 сая ширхэг хувьцаатай, нэг хувьцааны үнэ 20.65 ам доллар хэмээн тогтоосон байгаа ч зарим хүмүүсийн мэдээлснээр одоогоор нийт хувьцаагаа бүртгүүлээгүй байгаа гэжээ.

Зарим нэг шүүмжлэгч компаниуд болон шинжээчдийн зүгээс Твиттер Фэйсбүүк компаниас хойш амжилттай хувьцаа гаргах боломжгүй гэж үзсэн бол зарим нэг нь цахим ертөнцөд хүчээ авч буй хэрэгслүүдийн нэг хэмээн үзэж хувьцаагаа олон нийтэд санал болгохийг нь дэмжиж байгаа ажээ. Мөн хүмүүсийн дунд явуулсан санал асуулгаар гуравний нэг хувь нь тухайн компанийн хувьцааг сонирхож, хөрөнгө оруулалт хийх хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ.



ТАНЫ СОНИРХОЛД

Хотжилт ба Эдийн Засаг


Д. Дотно

УЛААНБААТАРЫН 300 мянган машины тал нь нэг цаг түгжрэнд зогсоход Монголчууд бензинд бараг 900 сая төгрөг алддаг. Жилээр нь тооцвол 330 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 3 хувийг түгжрэлд алддаг гэсэн тооцоо гарна. Жилийн 330 тэрбумаас гадна агаарын бохирдол, хүний бухимдал зэрэг амьдралын чанарын үзүүлэлт муудаж бид нийгмийн хэмжээнд хохирдог. Дээрээс нь явган алхахад улам бэрх болж байгаа гудамж дахь жижиг бизнесүүдэд учрах хор уршгийг хэмжсэн хүн байхгүй.

Хотод ийм асуудал гарах нь хөгжил, хүн амын нягтаршлаас үүссэн гэж хэлэхэд амархан боловч үнэндээ Улаанбаатарыг анх байгуулах үеийн хот төлөвлөлтийн тухай үзэл бодлын шууд үр дүн мөн. Машин олшрох нь нийслэлчүүдийн амьдралд шаардагддагийг л харуулж байна—Нью Йорк-ийн Манхаттан дүүрэгт 1.5 сая хүн амьдардаг нь Улаанбаатраас 79 дахин жижиг газарт сэлүүхэн багтдаг бөгөөд дундаж ажлын өдөрт 2.5 сая хүн энэ арал дээр нэмэгддэг тул хүний тооноос түгжрэл шууд хамаараагүй нь тодорхой. Машин хэрэгтэй болсны гол шалтгаан бол энэ: манай хотын орон сууцын хорооллууд нь ажил, бизнесийн хэсгүүдээсээ тусгаар байрлалтай бөгөөд оршин суугчид нь алхаж биш, автобусаар зорчих зориулалттай баригдсан.

Хотыг ингэж барих санаачлага нь архитектурын мэргэжилд 20-р зууны эхээр хийсэн хувьсгалаас үүссэн зүйл юм. Энэхүү хувьсгалын гол санааны эх үүсвэр нь

Хоуард Эбенезер-ийн цэцэрлэгт хотхон



Английн Хоуард Эбенезер хэмээх хүний 1898 онд бүтээсэн Цэцэрлэгт Хот ("Garden City") гэгч загвар мөн. ЗХУ, АНУ-ын аль аль нь хот төлөвлөлтийн бодлогодоо Цэцэрлэгт Хотын шинж чанарыг шингээжээ. Ийнхүү дэлхий даяар 21-р зууны шинэ нөхцөлд зохихгүй, аяндаа сөнөх аюултай субурбан (латин: sub-urban, хотын гадуурх) сууринууд үүссэн.

Цэцэрлэгт Хотын гол шинэлэг санаа нь хотын дүүргүүдийг хэрэглээгээр ялгаж, хүн амын нягтаршлыг багасгаж, хотын ард түмнийг байгаль, хөдөөтэй ойрхон мөртөө хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн ажлаар хангах жижиг хотод байршуулж тархаах юм. Харин ард түмнийг төрөөс зохион байгуулсан эдийн засгийн салбарт ажиллуулж, хотын хүн амыг хязгаарлах санаа нь барууны нийгмийн болон эрхзүйн үзэлд нийцэхгүй тул ийм элэметүүдийг АНУ гэх мэт улсуудад орхисон ч социалист ЗХУ-ын үзэл сурталд нийцсэн тул ийм хот төлөвлөлт нь дорнодод түгээмэл болсон. Харин АНУ болон бусад барууны оронд хувийн машин, алга дарам газар болон байшинтай байх ард түмний мөрөөдлийг биелүүлнэ гэсэн санаагаар анх хот, хөдөөгийн хооронд гэмээр субурбан сууринг бүтээж эхэлсэн.


АНУ-д субурбан сууринуудыг барихад автомашиныг

АНУ: 1950-иад оноос түгээмэл болсон тархмал суурин



хүн төрөлхтний ирээдүй гэж бодож, нефть дуусах байтугай ховордож үнэтэй болно ч гэж төсөөлөөгүй тул асфальтан замаар холбогддог, зөвхөн хувийн хаусаар бүрдэх хорооллээдыг улс даяар барьсан. Харин Зөвлөлтийн дизайнтай Улаанбаатар гэх мэт субурбан хотуудыг чөлөөтэй ажил эрхлэх, бизнестэй болж хөгжих ард түмэнд биш, Р. Чойномын хэлэхээр махны машинан амьдралтай коммунист нийгэмд зориулж зохиосон байдаг. Үйлдвэрийн ажилчид Үйлдвэр-Комбинатад, МУИС-ын багш нар их сургуулийн хажууд гэх мэт ажиллаж амьдрах газар нь цаанаасаа зохицуулалттай тул хүмүүс өдөр тутмын амьдралдаа хол явах шаардлагагүй байсан. Хүн чөлөөтэй хөдлөхөд энэ систем зохицолгүй нь тодорхой. Хувийн байранд бизнес эрхлэх боломж энэ системд бүр ч хамааралгүй нь бас мэдээж.


Өнөөдөр субурбан санаачлагатай хотууд дэлхийн өнцөг булан бүрт хуучирч, гэмт хэргийн асуудалд



нэрвэгдэж, эсвэл машины түгжрэлээс салж чадахгүй байгаа. Манай хотоос ялгаагүй. Учир нь эдгээр хотуудыг байгуулахад олон мянган жилийн турш шалгарч үлдсэн амжилттай хотуудаас ямар ч сургамж аваагүй байдаг. Өнөөдөр хуучин хот ихтэйгээрээ Европын орнууд хотыг төвлөрүүлэх, автомашины хараат амьдралаас салах тал дээр тэргүүлдэг ч АНУ, Японд аль хэзээ энэ тал дээр бас анхаарч эхэлсэн. АНУ болон Японы хүн ам нь хөгширч эхлэхэд уйтгартай, ирээдүйгүй хаус-ын хорооллууд хоосорсон. Залуучууд нь хөгжилтэй, алхаад оччих сонирхолтой газартай 20-р зуунаас өмнө баригдсан хотууд руу дүрвэж байна. Даанч Монгол улсад 20-р зууны алдаа болсон Цэцэрлэгт Хотын субурбан санаа Америк, Хятадыг дуурайх хэлбэрээр хамгийн мэднэй байгаа нь харуусалтай.

1961 онд "Их Хотуудын Үхэл ба Амьдрал" гэдэг номоор Нью Йорк болон Торонто-г субурбан болгох

АНУ: Гэрээс 190м зайтай супермаркет ороход 1.5 км алхана (хамгийн урт гудамж нь хурдны зам - явган хүний замгүй)



давалгаанаас хамгаалж чадсанаараа алдаршсан Жейн Жекобс-ын хэлснээр хотын дүүрэг, гудамжийг хөгжилтэй,

аюулгүй болгоход дөрвөн үндсэн салшгүй нөхцөл заавал бүрдсэн байх ёстой байдаг нь:

1. Олон хэрэглээнд зориулагдсан байх
2. Замын уулзварууд хоорондоо ойрхон байх
3. Шинэ хуучин байшингууд холигдсон байх
4. Хүн амын өндөр нягтаршилтай байх

Өөрөөр хэлбэл хот амжилттай оршин тогтнохын тулд маш нарийн, төвөгтэй, сонирхолтой байх хэрэгтэй бөгөөд хамгийн гол нь машин тэргийн биш, хүний амьдралын хэрэгцээг ямагт хангах тал руу чиглэж байх хэрэгтэй. Олон хэрэглээтэй байруудад хүн амьдарч, ажиллахаас гадна бүтэн өдөржин үйлчлүүлэгчид ирж явах тул хөл хөдөлгөөн ихтэй байдаг. Ойр ойрхон замуудтай бол хүн алхахад таатай байхаар барахгүй машин ч өдөр бүр олон замаар явах сонголттой болж, түгжрэлээс сэргийлж, нэмэгдсэн хөл хөдөлгөөний улмаас гудамж дахь бизнесийг хөгжүүлдэг. Хуучин байшны хямд өртөг нь хотын төвд мөнгө багатай байгууллага, иргэдийн нийгэмлэг, сургууль, шинэ бизнесд сайн байршилтай байх боломж олгож, хотыг амьдралыг төрөлжүүлж өгдөг. Мөн хүн амын өндөр нягтаршил нь хөдөлгөөн ихэсгэж, ойр хавийн бизнесүүдийг дэмждэг.

Улаанбаатарт эдгээр нөхцөл бүрдэх боломжийг Зөвлөлтийн төлөвлөлт анхнаас нь хориглосноор барахгүй хөгжлийн хандлага нь улам холдуулж байна. Хол тархаж суурьших нь байгаль орчин сүйтгэдгийг эс тооцвол уйтгартай, эрчим хүчийн үрлэг ихтэй, төрөөс гарах дэд бүтцийн зардлыг татвараар нөхөх боломжгүй, эдийн засгийн алдагдалтай байгууламжуудыг үүсгэдэг. Дээрхи нөхцлүүдийг бүрдүүлж чадаагүй газар хөгжилтэй хот суурин болох боломжгүй учир удалгүй хуучирна: өөрийгөө засаж шинэчлэх хөрөнгийн урсгал үүсгэхгүй тул нураагдах тавилантай. Энэ явц 20-р зууны турш АНУ, Япон, Англи гэх мэт орнуудад олон дахин давтагдсаны эцэст тэд харин олон мянган жилийн түүхтэй хотуудыг үлгэр дуурайл болгож эхэлсэн.

Бид ч бас амьд, үр ашигтай хотыг хэрхэн байгуулах талаар бодож эхэлмээр юм. Хятадуудыг дуурайж байгаа мэт хөдөөнөөс шинээр ирсэн нийслэлчүүдээ гадуурхаж, хүн амаа тархах, оюутнуудаа хотын төвөөс хөөх, шинэ хотын төв байгуулах, машины зам өргөтгөх тухай яриагаа больвол нийслэлээ аврах боломжтой. Харин бусад улсын байгаа байдлыг үлгэр жишээ болгохоос өмнө өөрсдийнх нь дүгнэлтийг сонсох л хэрэгтэй. •

Лондон: 2000 жилийн түүхтэй - 20-р зуунд зохиогдсон "шинэ" хэсгүүдээр л ядуурал, гэмт хэрэг, түгжрэлийн асуудалтай



THIS IS THE MICC JOURNAL, A BI-MONTHLY FINANCE AND ECONOMICS PAPER
PUBLISHED BY MICC, THE LEADING INVESTMENT CORPORATION IN MONGOLIA.

MICC хөрөнгө оруулалтын корпорацийн тухай

MICC нь компанийн санхүүжилт, үнэт цаасны арилжаа,
судалгаа, хөрөнгийн удирдлага зэрэг цогц үйлчилгээг

MICC ТЭМДЭГЛЭЛ – ийн тухай

Хоёр долоо хоног болгон гарах энэ бяцхан сонин
танд эдийн засаг, санхүүгийн мэдээлэл өгөх
боловч хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөхгүй.

ТАНЫ ЭРСДЭЛ ТАНЫ ХАРИУЦЛАГА.

Эрхлэгч: Э. Оюу.

2013/10/16

Мэдээллийн эх сурвалж:
Bloomberg, Монголын
Хөрөнгийн Бирж, MSCI Barra,
OECD.